

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

СУЛ ОРОН ТООГ НӨХӨХ ЗАР

2022.11.23

Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын “Сургалт хариуцсан шинжээч”-ийн албан тушаалын сул орон тоог нөхөхөөр зарлаж байна.

Нэг “Сургалт хариуцсан шинжээч”

1. Албан тушаалд тавигдах ерөнхий шаардлага

- Монгол Улсын иргэн байх;
- Дээд боловсролтой байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй;
- Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх (эрэгтэй);
- Төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагч байх.
- Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг бүрэн хангасан байх;

2. Албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Сул орон тоонд тухайн албан тушаалд тавигдсан боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг хангасан, энэ албан тушаалд ажиллахыг хүссэн төрийн жинхэнэ албан хаагч бүртгүүлнэ.

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	-Боловсрол /0111, 0114/; -Эдийн засаг /031101/; -Нягтлан бодох бүртгэл, татвар /041101/; -Менежмент ба удирдахуй /041301-041303/.	
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх эсхүл түүнтэй адилтгах сургалтад хамрагдаж төгссөн байх. Сургалт зохион байгуулах чиглэлээр мэргэшсэн буюу сургагч багшийн эрхтэй бол давуу тал .	
Туршлага	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.	
	Дүн шинжилгээ хийх	- ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ чадвартай хийх; - сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа, шинжилгээ хийх арга зүйн мэдлэг, чадвартай байх; - сургалтын үйл ажиллагааны статистик мэдээллийг нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах чадвартай байх - сургалтын явц, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг тодорхойлох чадвартай байх; - тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх чадвартай

		байх; - тоон болон чанарын судалгааг боловсруулах чадвартай байх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- албан тушаалын чиг үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид хараат бусаар гүйцэтгэх; - аливаа асуудлыг гүйцэтгэхдээ эрсдэл тооцох чадвартай байх; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг боловсруулах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусдыг сонсох чадвартай; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, ачаалал даах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - маргаантай асуудалд хүлээцтэй, нийцтэй ханддаг байх; - бүтээлч санаачилгатай ажиллах; - бусадтай ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - бусад.
	Бусад	- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх; - үндэсний бичгийн хэлээр уншиж бичих чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах, харилцах бичгийн болон ярианы бүрэн чадвартай байх; - сургалтын баримт бичиг боловсруулах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах чадвартай байх; - сургалтыг зайнаас буюу онлайн хэлбэрээр зохион байгуулах арга туршлагатай байх; - сургалтын технологи, арга зүйн мэдлэгтэй байх; - бусадтай зөв боловсон харилцах албан харилцааны ур чадвартай байх; - төрийн болон хувь хүний нууцыг хадгалах.

Хоёр. Шалгалт өгөхийг хүссэн албан хаагч бүртгүүлэхдээ дор дурдсан бичиг баримтыг цахимаар бүрэн ирүүлнэ. Үүнд:

- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;

- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичгийн хуулбар (диплом) Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар
- Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар эсхүл Цахим лавлагаа ("e-mongolia"- аас татан авах);
- "4 х 6"-ийн хэмжээний цээж зураг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт.
- Төрийн албанд ажилласан жил тооцох зорилгоор албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн "Тангаргийн хуудас" -ын хуулбар;
- Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн төвшинг үнэлсэн сүүлийн гурван жилийн үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (e-mongolia– аас татан авах) ;
- Сүүлийн 1 жилийн дотор ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээгээгүйг нотлох бичиг баримт;

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх

Албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад оролцох албан хаагчийн хүсэлт, холбогдох баримт бичгийг 2022.11.23-ны өдрийн 09:00 цагаас 2022.11.30-ны өдрийн 17:30 цаг хүртэл tusgai-shalgalt.burtgel@audit.gov.mn цахим хаягаар хүлээн авна.

Дөрөв. Хүсэлт ирүүлсэн албан хаагчдад мэдээлэл хүргэх:

Сул орон тоо нөхөх тусгай шалгалт өгөх хүсэлт ирүүлсэн албан хаагчийн бичиг баримтыг хянаж, албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан эсэх тухай мэдээлэл болон тусгай шалгалтыг зохион байгуулах хугацааг албан хаагчийн цахим хаягаар мэдэгдэнэ.

Холбоо барих утасны дугаар
Үндэсний аудитын газар: 51-261585

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР